

# Улсын Бүртгэгчид бүртгэл хийлгэх иргэдийн бүрдүүлэх материалын жагсаалт

## 16 насанд хүрч иргэний үнэмлэх анх удаа авах бүртгэл

-Анх удаа бүртгүүлэхэд: төрсний гэрчилгээ, Эцэг, эх эсхүл харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх, харгалзан дэмжигчийг тогтоолгосон бол эрх бүхий этгээдийн шийдвэр, хүүхэд асрамжийн газар амьдарч байгаа бол тухайн байгууллагын тодорхойлолт.

-Монгол улсын харьяат болсон, иргэний харьяалалаа сэргээн тогтоолгосон иргэн эрх бүхий байгууллагаас олгосон тодорхойлолтыг бүрдүүлж өөрийн биеэр бүртгүүлнэ.

Жич:Засаг захиргааны нэгж харгалзахгүй бүртгэнэ

## . Иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацаа сунган сольж олгоход бүрдүүлэх материал

- Хүсэлт /ИУБ-31 маягт/
- Төрсний гэрчилгээ
- Иргэний үнэмлэх
- Үнэ -18300 /15000 төгрөгийг голомт банкны 1165004534 дансанд тушаах, 3300 төг тэмдэгтийн хураамжийг тухайн дүүрэг, орон нутгийн татварын албанд тушаасан байна./

Биений давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлэхдээ эзэн заавал өөрийн биеэр оршин суугаа газрынхаа сум, дүүргийн улсын бүртгэлийн байгууллагад хандана.\

## Шинээр төрсөн хүүхдийг төрсний бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материал

- Өргөдөл./Хүүхдийг бүртгүүлэхийг хүссэн/
- Эцэг эхийн иргэний үнэмлэх
- Эцэг, эхийн гэрлэлтийн гэрчилгээ
- Гэрлэсний гэрчилгээгүй бол эцэг эхийн хамтран гаргасан өргөдөл./ Хүүхдээ эцгээр нь овоглохыг хүссэн /

Шинээр төрсөн хүүхдийг эцэг, эхийн оршин суугаа газрын, эсхүл хүүхдийн өөрийнх нь төрсөн газрын сум, дүүргийн улсын бүртгэлийн байгууллагад төв суурин газарт 15, хөдөө орон нутгийн алслагдсан сум, багт 30 хоногийн дотор хандан үнэ төлбөргүй бүртгүүлнэ.

## Гэрлэсний бүртгэлд бүртгүүлэхэд

- Гэрлэгчид тус тусдаа гаргасан өргөдөл
- Гэрлэгчдийн иргэний үнэмлэх
- Гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээний бичиг
- Гэрчийг байлцуулна./18 нас хүрсэн иргэн байна./

Жич:Засаг захиргааны нэгж харгалзахгүй бүртгэнэ.

## Гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлэхэд

- Тус тусдаа гаргасан өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Гэрлэлт цуцалттыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол эрх бүхий этгээдийн шийдвэр

Жич:Засаг захиргааны нэгж харгалзахгүй бүртгэнэ.

## Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл

### ЗАХИРГААНЫ ЖУРМААР

- Тус тусдаа гаргасан өргөдөл
  - Иргэний үнэмлэх
  - Гэрлэлтийн гэрчилгээ
- ШҮҮХИЙН ЖУРМААР**
- Иргэний үнэмлэх
  - Гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр

### Эцэг /эх/тогтоосны бүртгэлд бүртгүүлэхэд

- Эцэг, эхийн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Гэрлэлтийн гэрчилгээ
- Хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх
- Эцэг /эх/ болохыг шүүхээр тогтоолгосон бол шүүхийн шийдвэр

### Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэлд бүртгүүлэхэд

- Өргөдөл
- Төрсний гэрчилгээ
- Иргэний үнэмлэх
- Гэрлэсэн бол гэрлэлтийн гэрчилгээ
- Хүүхэдтэй бол хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх
- Иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай иргэний хувьд харгалzan дэмжигчийн зөвшөөрөл
- Иргэний эрх зүйн зарим чадамжтай иргэний хувьд түүний эцэг эх, эсхүл асран хамгаалагчийн зөвшөөрөл
- Иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон бол шүүхийн шийдвэр.

Жич: Засаг захиргааны нэгжийн харьяаллаар бүртгэнэ.

### Үрчилсний бүртгэлд бүртгүүлэхэд

- Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч сум, дүүргийн Засаг даргад өөрийн биеэр хандаж өргөдлөө өгнө.
- Засаг даргын захирамжийг үндэслэн үрчилсний бүртгэлийг хөтөлнө.
- Жич: Засаг захиргааны нэгжийн харьяаллаар бүртгэнэ.

### Нас барсны бүртгэлд бүртгүүлэхэд

- Нас барсан тухай эмнэлгийн магадлагаа эсхүл шүүхийн шийдвэр, шүүх эмнэлгийн дүгнэлт, гамшгийн улмаас амь нас нь эрсэдсэн бол онцгой комиссын шийдвэр.
- Жич: Засаг захиргааны нэгж харгалзахгүй бүртгэнэ.

### Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд

- Иргэний үнэмлэх
  - 16 нас хүрээгүй хүүхэдтэй иргэн оршин суух бол хүүхдийн төрсний гэрчилгээ
  - Оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг /эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших, ашиглах гэрчилгээ, нотариатаар гэрчлүүлсэн түрээсийн, захиалгын гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эсхүл эзэмшигчийн бичгээр гаргасан оршин суулгах тухай зөвшөөрөл/
- Жич: Засаг захиргааны нэгжийн харьяаллаар бүртгэнэ.

### Хүйс Өөрчлөгдсөний Бүртгэл

- Өргөдөл
  - Иргэний үнэмлэх
  - Төрсний гэрчилгээ
  - Эмнэлгийн байгууллагаас хүйс өөрчлөгдсөнийг нотолсон баримт бичиг
- Жич: Зөвхөн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Иргэний улсын бүртгэлийн газарт бүртгэнэ.